



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 5/167

Улаанбаатар хот

**Мөнгөн шагнал олгох тухай**

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8, 9.6.10 дахь заалт Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга нэвтрүүлж, мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж ажилласныг нь үнэлэн хавсралтад дурдсан нэр бүхий албан хаагчдад нэг сарын үндсэн цалингийн 50.0 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг тус тус олгосугай.

2.Мөнгөн шагналд олгогдох зардлыг зохих зардлаас гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т зөвшөөрсүгэй.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА С.БАТБОЛД



080001188